



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг
хангаж ажиллах тухай

Улсын хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар Нийслэлийн 7 дүүрэг, 15 аймагт нийт 2706 хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. Үүнээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буцсан 2196, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан 419, одоо хянагдаж/хэвтэн эмчлүүлж байгаа 2, нас барсан 57 тохиолдол байна. Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг амьдардаг байршлаар нь авч үзвэл нийт тохиолдлын 95.3% /2580/ нь Улаанбаатар хотод, 4.6% /126/ нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна.

Сүүлийн 5 жилийн тандалтын мэдээллээр угаарын хийн хордлогын тохиолдол буурахгүй, айл өрхийн галлагаатай холбоотой жил бүрийн 10 дугаар сараас эхлэн дараа оны 06 дугаар сар хүртэл иргэд угаартсаны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирох тохиолдол бүртгэгдэж байна. Айл өрхийн галлагааны горим алдагдах, галлагаатай үед яндангийн сойлт хаах, монгол гэрийн өрхийг бүтээх, бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхих зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Нийт тохиолдлын 16% нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 81.4% нь яаралтай тусламж үйлчилгээ авч, гэртээ буцаж байгаатай холбоотой энэ чиглэлээр баримталж буй оношилгоо, эмчилгээний стандарт, зааврын хэрэгжилтийг хангуулах, аймаг, нийслэлийн өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх, гэрийн хяналтыг сайжруулах, дахин хордлогод өртөхөөс сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байгаа тул урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахаар бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАХ нь.

Нэг. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

- 1.1 Монгол Улсын стандарт “Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ийн цочмог хордлогын оношилгоо, эмчилгээ MNS 6449:2014”, эмнэл зүйн зааврыг оношилгоо, эмчилгээндээ мөрдөх;
- 1.2 Угаарын хийн хордлогын үеийн оношилгоо, эмчилгээний заавар, зөвлөмжийг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж, ажлын байрны сургалт зохион байгуулах;

143230028

- 1.3 Нийт тохиолдлын дийлэнх нь эмнэлгийн яаралтай тусламж авч, гэрийн хяналтад буцаж байгаа тул өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн гэрийн хяналтыг сайжруулах, эрхтэн тогтолцооны эмгэгийн хүндрэлээс сэргийлэх, эргэн хянах, дахин хордлогод өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх;
- 1.4 Угаарын хийн хордлогын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах, мэдээллийг холбогдох байгууллагуудад цаг тухай бүрд мэдээлэх;
- 1.5 Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлэхдээ айл өрхийн галлагаа, хийн зуух, цахилгаан хэрэгсэл, угаар мэдрэгчийн аюулгүй байдлыг хангах талаар заавар зөвлөгөө өгч, эрсдэлтэй тохиолдолд орон нутгийн мэргэжлийн байгууллагад мэдээлэх, ялангуяа бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд онцгой анхаарал хандуулах;
- 1.6 ЭХЭМҮТ, ХЯТҮТ, Нийслэлийн түргэн тусламжийн төв (103), анхан шатны сум, өрхийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад карбоксигемоглобин (СНb) буюу нүүрстөрөгчийн дутуу ислийг тодорхойлох оношилгооны төхөөрөмжөөр хангах асуудлыг судалж шийдвэрлэх;

Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр:

- 2.1 Угаарын хийн хордлогын шалтгаан нөхцөл, эрсдэлт хүн ам, эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах арга хэмжээг хэрэгжүүлж, нотолгоонд суурилсан нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.2 Эрсдэлт айл өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, интернэт цахим хэрэгсэл хүрэлцээгүй, алслагдмал хаягт амьдарч байгаа айл өрхүүдэд угаарын хийн хордлогоос сэргийлэх зөвлөмжийг хүрч очиж, түгээх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.3 Орон нутгийн Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагатай хамтран угаарын хийн хордлогоос сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр буюу гэр хорооллын шахмал түлш борлуулах цэг, худаг, буудал, нийтийн байр, айл өрхөд хэвлэж тараах, байршуулах;
- 2.4 Цагдаагийн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагууд нас баралт бүртгэгдсэн газраас нүүрс, үнснээс дээж авч, шинжилгээний хариуг эргэн мэдээлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран нэгдсэн төлөвлөгөө гарган ажиллах;
- 2.5 Олон нийтийн телевиз, мэдээллийн сувгуудыг татан оролцуулж, сэрэмжлүүлэг, мэдээллийг тогтмол түгээх;
- 2.6 Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу үйл явдалд олон эх сурвалж ашиглан салбар хооронд мэдээлэх, үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийх, тохиолдлын удирдлагын тогтолцоо, хариу арга хэмжээг шуурхай байгуулж ажиллах;

Албан даалгаврыг хэрэгжүүлж авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн тайланг заалт бүрээр гаргаж 2024 оны 03 дугаар сарын 01-ний дотор тус яамны Нийтийн эрүүл мэндийн газар болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт ирүүлнэ.

САЙД  С.ЧИНЗОРИГ

